



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/620

Улаанбаатар хот

Өндөржүүлсэн бэлэн байдалд
шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар хуралдааны шийдвэр, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/69 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийт нутаг дэвсгэрт өвөлжилт, хаваржилт хүндэрч байгаатай холбогдуулан бэлэн байдлыг хангах зорилгоор 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд эрүүл мэндийн салбарыг өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлсүгэй.

2. Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлсэнтэй холбогдуулан эрүүл мэндийн байгууллагын өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах түр төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Малчид, иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс (Б.Батцоож)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалыг хэрэгжүүлж, мөрдөж ажиллахыг харьяа эрүүл эрүүл мэндийн байгууллагын дарга, захиралт нарт даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт удирдлагын хэлтэс (У.Бат-Очир)-т даалгасугай.

ДАРГА



П.ЭРХЭМБУЛГАН

1550010053

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 02 дугаар сарын 21-ны өдрийн
тушаалын хавсралт



**ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАХ ТҮР ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл	Хугацаа	Хариуцах албан тушаалтан	Хэрэгжүүлэх байгууллага
1	Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэн талаар байгууллагын ажилтан албан хаагчдад танилцуулан, үүрэг чиглэл өгч, зохион байгуулалтын арга хэмжээ авах;	02/21-05/15	Харьяа эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нар	Харьяа эрүүл мэндийн байгууллага
2	Өндөржүүлсэн бэлэн байдалд эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангаж, ажиллах хүний нөөц, эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуур, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, хүчилтөрөгчийн хангамж, унаа шатахууны нөөцийг бүрдүүлэх;	02/21-05/15	Харьяа эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нар	Харьяа эрүүл мэндийн байгууллага
3	Өндөржүүлсэн бэлэн байдлын үед гарсан шийдвэр, үүрэг чиглэлийг тухай бүрт хэрэгжүүлж ажиллах;	02/21-05/15	Харьяа эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нар	Харьяа эрүүл мэндийн байгууллага
4	Харьяа эрүүл мэндийн байгууллага бүр бэлэн байдлын тусгай горимд шилжин, цагийн хуваарийн дагуу ажиллах;	02/21-05/15	Харьяа эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нар	Харьяа эрүүл мэндийн байгууллага
5	Ажилтан албан хаагчдын ажил, үүрэг гүйцэтгэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх, хоол хүнс, хувцас, техник хэрэгслээр хангах, аюулгүй ажиллагааг сахиулах, эрүүл мэндэд анхаарч ажиллах;	02/21-05/15	Харьяа эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нар	Харьяа эрүүл мэндийн байгууллага
6	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тасралтгүй бэлэн байдлыг хангаж эрүүл мэндийн байгууллагууд гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх;	02/21-05/15	Харьяа эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нар	Харьяа эрүүл мэндийн байгууллага
7	Байгууллага, салбар, нэгжийн хэмжээнд ажиллах шуурхай штаб, эргүүл, жижүүрийг томилон удирдлага, зохион	02/21-05/15	Харьяа эрүүл мэндийн байгууллагын	Харьяа эрүүл мэндийн байгууллага

	байгуулалтаар хангаж ажиллах;		дарга, захирал нар	
8	Отроор өвөлжиж буй эрсдэлт бүлгийн хүн амын судалгааг 14 хоног тутамд шинэчлэн нягталж, Нийслэлийн Эрүүл мэндийн газарт ирүүлэх;	02/21-05/15	Харьяа эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нар	Харьяа эрүүл мэндийн байгууллага, ДЗДТГ
9	Нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Нийслэлийн Эрүүл мэндийн газарт тухай бүрт шуурхай танилцуулах;	02/21-05/15	Харьяа эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нар	Харьяа эрүүл мэндийн байгууллага
10	Харьяа эрүүл мэндийн байгууллагууд өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин ажиллаж байгаа тайланг долоо хоног бүрийн баасан гарагийн 14.30 цагаас өмнө Нийслэлийн Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтэст бичгээр болон цахимаар ирүүлэх.	02/21-05/15	Харьяа эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нар	Харьяа эрүүл мэндийн байгууллага

Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэн үеийн зохион байгуулалтын арга хэмжээ, эрх, үүргийг зөрчсөн ажилтан, албан хаагчдыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---ooOoo---